



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 25/92

Улаанбаатар хот

Хуулийн этгээдийн дүрэм шинэчлэн  
батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргээдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Шинэчлэн батлагдсан дүрмийн өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн хороо (Б.Сэмжидмаа)-нд даалгасугай.

4.Энэхүү тогтоолыг баталсантай холбогдуулан Нийслэлийн иргээдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 24 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  А.БАЯР

1725010032

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн  
*25/92* дүгээр тогтоолын хавсралт

**“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР”  
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах хуулийн этгээд мөн.

1.2.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь (цаашид “үйлдвэрийн газар” гэх) Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай, Барилгын тухай, Хот байгуулалтын тухай, Иргэний хууль, Төсвийн тухай, Компанийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, хүчин төгөлдөр мөрдөж буй норм норматив, стандартууд болон бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамж, нийслэлийн урт, дунд, богино хугацааны хөтөлбөр, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

**Хоёр. Үйлдвэрийн газрын оноосон нэр, оршин байгаа хаяг**

2.1. Үйлдвэрийн газрын оноосон нэр нь “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байх ба товчилсон нэр нь “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ байна.

2.2. Үйлдвэрийн газар нь албан ёсны цахим шуудан болон цахим хаягтай байна.

2.3. Үйлдвэрийн газрын хаяг: Улаанбаатар хот, тухайн хуулийн этгээдийн байрлаж байгаа газраар тодорхойлогдох бөгөөд хаягийн өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

**Гурав. Үйлдвэрийн газрын бэлгэдэл, тэмдэг**

3.1. “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг хэрэглэнэ.

3.2. Тамга, тэмдгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.3. Тамга, тэмдгийг газрын захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

3.4. Үйлдвэрийн газар нь бэлгэдэл (эмблем, лого)-тэй байна. Бэлгэдлийн загварыг Захирал баталж, түүнийг ашиглах эрхийг үйлдвэрийн газар эдэлнэ.

#### **Дөрөв. Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд баримтлах зарчим**

4.1. Үйлдвэрийн газар нь дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримтална:

- 4.1.1. хууль дээдлэх;
- 4.1.2. үнэнч шударга байх;
- 4.1.3. хүнлэг, энэрэнгүй байх;
- 4.1.4. захирах, захирагдах ёсыг баримтлах;
- 4.1.5. манлайлах, хамтаж байх;
- 4.1.6. төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй шуурхай хүргэх;
- 4.1.7. хүнд суртал, авлига, хээл хахууль, шан харамжаас ангид байх;
- 4.1.8. иргэд, гүйцэтгэгчдийг хүндэлж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагад хүндэтгэлтэй хандах;
- 4.1.9. үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх.

#### **Тав. Үйлдвэрийн газрын алсын хараа, эрхэм зорилго**

5.1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны алсын хараа нь Хүрээлэн буй орчинд ээлтэй чанарыг эрхэмлэсэн бүтээн байгуулалтыг цогцлооно.

5.2. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Олон улсын түвшинд нийцсэн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.

#### **Зургаа. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зорилго, үндсэн чиг үүрэг**


6.1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилго нь Захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх замаар шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэхэд оршино.

6.2. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагааны дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.2.1. улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусlamжийн болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих;

6.2.2. хөрөнгө оруулалтын судалгаа шинжилгээний үр дүнгийн саналаа холбогдох газарт хүргүүлэх, хамтран ажиллах;

6.2.3. зураг төслийг хянах, түүний хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах, зураг төсвийн ажилд гэрээний үндсэн дээр хяналт тавих;



6.2.4.захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах, төсөл, арга хэмжээний техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдлийг хянаж, захиалагчид хүргүүлэн батлуулах;

6.2.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ил далд ажлын актыг баталгаажуулах, материалын стандартыг хангуулах, шаардлага тавих;

6.2.6.эрх шилжсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавих, бүртгэх тайлагнах, үр ашгийг нэмэгдүүлэх санал боловсруулан хэрэгжүүлэх;

6.2.7.төсөл, арга хэмжээний хүрээнд шинэ техник технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх;

6.2.8.хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлж болно.

6.3.Үйлдвэрийн газрын дүрэмд өөрчлөлт орсон тохиолдолд хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

6.4.Үйлдвэрийн газрыг хувьчлах, өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагаа нь Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдана.

#### **Долоо.Үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх**

7.1.Үйлдвэрийн газар нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, хариуцлага хүлээнэ.

7.2.Үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

7.2.1.өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;

7.2.2.эргэлтийн бус хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газраас олгосон эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

7.2.3.үйлдвэрийн газрын үйл ажиллагааны дунд олсон эрх хэмжээний дотор захиран зарцуулах тогтоосон ногдол ашгийг төсөвт төвлөрүүлж үлдэх хэсгийг зохих журмын дагуу захиран зарцуулах;

7.2.4.үйлдвэрийн газар нь эргэлтийн бус хөрөнгийг зөвхөн Нийслэлийн Өмчийн харилцааны газрын шийдвэрийг үндэслэн шинээр бэлтгэх, акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх эрхтэй.

#### **Найм.Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц**

8.1.Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батална.

8.2.Үйлдвэрийн газрын бүтцийн нэгж үйл ажиллагааныхаа явц, үр дүнг газрын Захирлын өмнө хариуцан тайлagnана.

8.3.Үйлдвэрийн газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай хариуцлагын гэрээ, төлөөлөл хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагатай холбогдох гэрээг байгуулан биелэлтийг ханган ажиллана.

8.4.Үйлдвэрийн газар нь хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамж, үүрэг, даалгавар, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааны явц, үр дүнг тогтоосон хугацаанд холбогдох газарт тайлagnana.

#### **Ес.Үйлдвэрийн газрын удирдлагын тогтолцоо**

9.1.Захирлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

9.2.Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг Захирал удирдана.

9.3.Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан байна.

9.4.Үйлдвэрийн газарт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор томилогдсон Удирдах зөвлөл ажиллана.

9.5.Удирдах зөвлөл нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан “Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам”-д заасан эрх, үүргийн хүрээнд ажиллана.

9.6.Захиралд зөвлөх үүрэг бүхий Захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Захирал батална.

9.7.Захирал нь дор дурдсан эрх, үүрэг хэрэгжүүлнэ:

9.7.1.холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрийн газрын дүрэм, зорилтын санал, төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

9.7.2.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагааг хангаж санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг явуулах;

9.7.3.үйлдвэрийн газрын хэмжээнд Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

9.7.4.албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх, хувийн ашиг сонирхлоос ангид, тэгш шударгаар ажиллах нөхцөл бүрдүүлэх;

9.7.5.нийслэлийн Засаг даргын баталсан удирдлагын бүтэц зохион байгуулалтын хүрээнд цалингийн хэмжээ, урамшууллын журам, дотөөд журмыг тогтоож мөрдүүлэх, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг батлах,



ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх;

9.7.6.хариуцсан үндсэн чиг үүрэгт хамаарах асуудлаар удирдах албан тушаалтанд хандаж санал гаргах, шийдвэрлүүлэх;

9.7.7.хариуцсан үндсэн чиг үүрэгт хамаарах асуудлаар удирдах албан тушаалтан, холбогдох байгууллага, албан хаагчдыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах;

9.7.8.хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх, үүрэг.

9.8.Захирал нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Нийслэлийн Өмчийн харилцааны газраас олгосон эрх хэмжээний хүрээнд газрын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

9.9.Захирал нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

9.10.Захирал өөрийн эрх үүргийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай зөвшилцэж итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрх үүргээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

#### **Арав.Үйлдвэрийн газрын хяналт**

10.1.Үйлдвэрийн газар нь үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг Захирал батална.

10.2.Холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулна.

10.3.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон санхүүгийн үйл ажиллагаанд Нийслэлийн Өмчийн харилцааны газар хяналт тавьж ажиллана.

10.4.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг Ерөнхий нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

10.5.Үйлдвэрийн газрын хариуцсан чиг үүрэгт хамаарах захиргааны эрх хэмжээний асуудлаар зөвлөмж, чиглэл өгөх, мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийн удирдлагыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ.

#### **Арван нэг.Үйлдвэрийн газрын санхүү, бүртгэл, тайлан**

11.1.Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бodoх бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

11.2.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Захирал, Ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.



11.3.Үйлдвэрийн газрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

11.4.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторын байгууллагыг сонгон ажиллуулна.

11.5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, Удирдах зөвлөлөөрөө хэлэлцүүлэн Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлнэ.

**Арван хоёр.Үйлдвэрийн газрын санхүүжилт, санхүүгийн болон  
үйл ажиллагааны тайлан**

12.1.Үйлдвэрийн газрын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ.

12.1.1.захиалагчийн техникийн хяналтын зардал;

12.1.2.хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр;

12.2.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана.

12.2.1.баланс;

12.2.2.үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

12.2.3.мөнгөн гүйлгээний тайлан;

12.2.4.өмчийн өөрчлөлтийн тайлан;

12.2.5.тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл үнийн дүн, удирдлагад олгосон цалин, шагнал урамшуулал;

12.2.6.нэмэлт тайлбар;

12.2.7.санхүүгийн тайлангийн тодруулга;

12.2.8.бусад.

12.3.Захирал нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн Өмчийн харилцааны газарт тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн тайлан, илтгэх хуудас хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана.

12.3.1.тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;

12.3.2.тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын албан тушаалтан, ажиллагсадад олгосон шагнал урамшуулал, нийгмийн халамж, зардлын хэмжээ;

12.4.Шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар.



## **Арван гурав.Үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах**

13.1.Үйлдвэрийн газар нь дараах бичиг баримтыг хадгална.

13.1.1.үйлдвэрийн газрын дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, үйлдвэрийн газрыг байгуулах тухай холбогдох газрын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ, газар эзэмших гэрчилгээ болон бусад тусгай зөвшөөрөл, гэрчилгээ сертификатууд;

13.1.2.санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжүүд;

13.1.3.анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгасан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

13.1.4.үйлдвэрлэл, технологи, норм нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, зааврууд бусад бичиг баримтууд;

13.1.5.хурлын тэмдэглэл, шийдвэр, даргын гаргасан тушаал, шийдвэрүүд;

13.1.6.бусад ач холбогдол бүхий бичиг баримтууд;

13.2.Дээрх бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хулээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах архивд шилжүүлэх зэрэг ажлыг холбогдох ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

## **Арван дөрөв.Үйлдвэрийн газрыг татан буулгах**

14.1.Үйлдвэрийн газрыг Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу татан буулгана.

## **Арван тав.Бусад**

15.1.Хуульд нийцүүлэн дүрэмд тусгаснаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

15.2.Үйлдвэрийн газрын энэхүү дүрэм нь Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.